



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

“Батширээт” ХК-ийн
үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн, ТОГТООХ нь:

1. “Батширээт” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 73,972 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
2. Өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд шаардах эрх үүссэн тухай болон уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдэгдлийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш 5 хоногт багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэхийг “Батширээт” ХК /Ш.Болдбаатар/-д үүрэг болгосугай.
3. Хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг нэг хувьцаанд 133.7 /нэг зуун гучин гурван төгрөг далан мөнгө/-өөр тооцож “ҮЦТТТХТ” ХХК-тай гэрээ байгуулж мөнгөн хөрөнгийг байршуулахыг “Батширээт” ХК /Ш.Болдбаатар/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.
4. Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдан авах шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэг хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай олгож ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.

001485

5. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг тэмдэглэсүгэй.

6. Ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршуулахдаа энэхүү тогтоолын 5-д заасан эрх тухайн дансны эзэнд үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрд зохих тайлбарыг өгч ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын 5-д заасан хүсэлтийг гаргасан тохиолдолд компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдэд шилжүүлэн компанийн дүрмэндээ зохих өөрчлөлтийг оруулан өмчлөх эрхийг нь баталгаажуулах, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны хадгаламжийн төвийн дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг компанид шилжүүлж ажиллахыг “Батширээт” ХК /Ш.Болдбаатар/-д, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

8. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН